МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 25 өдөр Дугаар 326 Улаанбаатар хот

# Төслийн удирдах хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2015 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Цахим эрүүл мэнд” төслийн Санхүүжилтийн хэлэлцээрийн 1 дүгээр хэсгийн А.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Цахим эрүүл мэнд” төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай.

2.Удирдах хорооны үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Удирдах хорооны дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

Хавсралт: 1 хуудас

САЙД Г.ШИЙЛЭГДАМБА

081148

Эрүүл мэнд спортын сайдын
2015 оны .08. сарын .25. өдрийн
326 дугаар тушаалын хавсралт

“Цахим эрүүл мэнд төсөл”-ийн Удирдах хорооны бүрэлдэхүүн

| | |
|---|---|
| Дарга: | ЭМСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | ЭМСЯ-ны Гадаадын зээл, тусламжийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд: | ЭМСЯ-ны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга |
| | ЭМСЯ-ны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга |
| | ЭМСЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга |
| | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дарга |
| | Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын Мэдээллийн Технологийн хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/ |
| | Засгийн Газрын ахлах референт /зөвшилцсөнөөр/ |
| | СЯ.ны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын дарга /зөвшилцснөөр |
| | Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Иновацийн албаны дарга /зөвшилцснөөр/ |
| | Монголын мэдээлэл технологи техник хөгжүүлэлтийн холбооны гишүүн /зөвшилцснөөр/ |